



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/16.

Улаанбаатар хот

**Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
дүрмийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дүрэм"-ийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Хурлын дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид болон Ажлын албанд тус тус даалгасугай.


3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 1025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
11/16 дугаар тогтоолын хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрмийн зорилго нь нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Зөвлөл, Хурлын хороо, нам, эвслийн бүлэг, Ажлын алба, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, чиглэлийг тогтоох, зохион байгуулалт, үйл ажиллагааг нь нарийвчлан зохицуулахад оршино.

1.2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль, энэхүү дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулна.

Хоёр.Хурлын бүрэн эрх, бүтэц, бүрэлдэхүүн

2.1.Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид Хурал гэх) нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын бүхий л асуудлыг хэлэлцэж, бие даан шийдвэрлэх эрх бүхий нутгийн өөрөө удирдах байгууллага мөн.

2.2.Хурал нь орон нутгийн сонгуулиар Хурлын Төлөөлөгчөөр сонгогдож, бүрэн эрх нь баталгаажсан, дүүргийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх Төлөөлөгчдөөс бүрдэнэ.

2.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.3.1.Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай асуудал;

2.3.2.Хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;

2.3.3.тухайн Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх;

2.3.4.тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх;

2.3.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.3.6.тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.3.7.хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг даргыг огцруулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж, дээд шатны Засаг даргад уламжилна.

2.3.8.нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2.3.9.Засаг даргын өргөн мэдүүлснээр дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;

2.3.10.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

2.3.11.орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;

2.3.12.орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

2.3.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;

2.3.14.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх;

2.3.15.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих;

2.3.16.худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;

2.3.17.хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэгт иргэдийг татан оролцуулах, саналыг нэгтгэн хууль санаачлагчид уламжлах;

2.3.18.хуульд заасан бусад бүрэн эрх;

2.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Хурлын дарга, Төлөөлөгчид, Хурлын Зөвлөл, Хурлын хороод, нам, эвслийн бүлэг, Ажлын алба гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй байна.

2.5.Хурал нь дэргэдээ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс зэрэг хууль тогтоомжид заасан нэгж ажиллуулахаас гадна өөрийн санаачилгаар бусад комисс, зөвлөлийг ажиллуулж болно.

Гурав.Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

3.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2.Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг Хурлын Зөвлөл болон Хурлын хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар урьдчилан хэлэлцүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтны илтгэл, мэдээллийг сонссон байна.

3.3.Хурлын хуралдааны үйл ажиллагааг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хурлын хуралдааны дэгийн дагуу зохион байгуулах бөгөөд дэгийг Хурал өөрөө батална.

3.4.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай холбогдолтой дүрэм, журмыг Хурлын хуралдаанаар хэлэлцэн баталж, нэмэлт өөрчлөлт оруулна.

3.5.Хурлын үйл ажиллагаа нь Хурлын хуралдаан, Зөвлөлийн хуралдаан, Хурлын хороодын, нам, эвслийн бүлэг, Ажлын албаны хурал болон зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжинэ. Шаардлагатай үед хуралдааныг иргэдийн оролцоотой нээлттэй, хаалттай, цахим хэлбэрээр зохион байгуулна.

3.6.Хурлаас эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ.

3.7.Хурлаас гарах захиргааны хэм хэмжээ тогтоосон акт нь Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

3.8.Хурал дэргэдээ Иргэний танхимтай байх бөгөөд Хурлаас гарах шийдвэрийн төсөл, хэлэлцэж буй асуудлаар уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдийн оролцоог хангаж ажиллана.

Дөрөв.Хурлын даргын бүрэн эрх

4.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.тухайн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангах;

4.1.2.тухайн Хурлын хуралдааныг даргалах, гарсан шийдвэрийг ёсчилж баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.1.3.Хурлын хороо, төлөөлөгчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоогоор хангах ажлыг зохион байгуулалтын удирдлагаар хангах;

4.1.4.эрх бүхий этгээдээс Хурлаар хэлэлцүүлэхээр тавьсан саналыг хүлээн авах, гарах шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.5.Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;

4.1.6.Хурлын нарийн бичгийн даргыг хуульд заасан журмын дагуу томилох, чөлөөлөх;

4.1.7.Хурлын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

4.1.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулан биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

4.1.9.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

4.1.10.тухайн Хурлыг дотоод, гадаадад төлөөлөх;

4.1.11.Хуралд ажлаа жил бүр тайлагнах;

4.1.12.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Тав.Хурлын Төлөөлөгчийн эрх, үүрэг, баталгаа

5.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч дараах эрх, үүрэгтэй байна:

5.1.1.асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;

5.1.2.Хурлын хороонд харьяалагдах;

5.1.3.хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асууж хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах;

5.1.4.Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;

5.1.5.Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх, санал гаргах;

5.1.6.Хурлын шийдвэрийг сонгогчдод сурталчлан таниулах;

5.1.7.Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулт, асуулга тавих;

5.1.8.сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан хариуг хуульд заасан хугацаанд авах;

5.1.9.үйл ажиллагаагаа жилд нэг удаа сонгогчдод тайлагнах;

5.1.10.хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийг иргэдийн дунд зохион байгуулж, тэдний саналыг авч, нэгтгэх;

5.2.Хурлын Ажлын алба, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн, арга хэмжээнд идэвхтэй оролцох;

5.3.Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг тогтоосон хугацаанд холбогдох хууль журмын дагуу үнэн зөв мэдүүлэх;

5.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

5.5.Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

5.6.Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан дэмжлэг, тусалцаа үзүүлэх үүрэгтэй.

5.7.Улс төрийн нам, бусад байгууллага төлөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, үүрэг хүлээлгэхийг хориглоно.

5.8.Улсад үр бүтээлтэй ажиллаж тодорхой амжилт гаргасан Хурлын Төлөөлөгчийг Монгол Улсын төрийн дээд цол, одон медаль, холбогдох бусад шагналд нэр дэвшүүлж уламжилна.

Зургаа.Хурлын төлөөлөгчид хүлээлгэх хариуцлага

6.1.Хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй, Хурлын дэг зөрчсөн, эсхүл үйл ажиллагаагаа хуульд заасны дагуу тайлагнаагүй бол Хурлаас дараах хариуцлага хүлээлгэнэ:

6.1.1.сануулах;

6.1.2.хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;

6.1.3.санал хураалтаас бусад үйл ажиллагаанд оролцох эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;

6.1.4.асуудал оруулах эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;

Долоо.Хурлын зөвлөлийн эрх, үүрэг

7.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.

7.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь дараах асуудлыг хэлэлцэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж болно.

7.2.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авах шуурхай арга хэмжээ;

7.2.2.нийтийн эрүүл мэнд, тээвэр, ундны ус, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт зэрэг хүн амын тулгамдсан асуудал;

7.2.3.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас урьдчилан эрх олгосон бусад асуудал;

7.2.4.энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.

Найм.Хурлын Хороо, түүний эрх, үүрэг

8.1.Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана.

8.2.Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаанд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос сонгоно.

8.3.Хороо тухайн Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

8.4.Хурал нь судалгаа, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий бусад хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

8.5.Хорооны үйл ажиллагааны чиглэл, тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн хороо, ажлын хэсэг байгуулах, хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг Хурал өөрөө тогтооно.

Ес. Дүүргийн ИТХ дахь намын бүлэг, нам, эвслийн бүлгийн бүрэн эрх, үүрэг

9.1.Хуралд 5-аас доошгүй суудал авсан нам, эвсэл нь бүлэг байгуулж болох бөгөөд бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн дарга, бүлгийн гишүүдийн нэрийг Хурлын даргад өргөн мэдүүлж Хуралдаанд танилцуулна. Хурал дахь нам эвслийн бүлэг нь ажиллах журмаа батална.

9.2. Нам, эвслийн бүлгүүд ажлын төлөвлөгөөг жилээр баталж, хэрэгжилтийг хагас жил тутам гарган тайлагнана.

9.3. Нам, эвслийн бүлэг нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар Хурал болон Хурлын даргад саналаа илэрхийлж болно.

Арав. Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд
Ажлын албаны даргын эрх, үүрэг

10.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Ажлын албатай байна.

10.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.

10.3.Ажлын албаны дарга нь тухайн Хурлын нарийн бичгийн дарга байх бөгөөд орон тооны байна.

10.4.Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга тушаал гаргана.

Арван нэг. Ажлын алба, түүний чиг үүрэг

11.1.Хурлын үйл ажиллагааг Төрийн албаны стандартын дагуу зохион байгуулж, Хуралдааны бэлтгэл хангах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, Хурал, Төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын алба ажиллах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

11.1.1.Ажлын алба нь Хурлын тогтоол, бусад шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж, шийдвэрийн биелэлтэд тавих хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах;

11.1.2.Хурлын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг нэгтгэн танилцуулах;

11.1.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, нийслэл, дүүргийн хурлын сонгуулийн бэлтгэлийг хангах, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, сонгуулийн хороодыг арга зүйн удирдлагаар хангах;

11.1.4.Хуулийн төсөл болон Хурлаас гарах шийдвэрийн төслийг иргэдээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах асуудлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

11.1.5.Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдол, мэдээллийг хүлээн авч хууль журмын дагуу шийдвэрлэх;

11.1.6.Хурлаас баталсан тогтоол шийдвэрийг иргэд, олон нийтэд үнэн зөв сурталчлан таниулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

11.1.7.Хурлын Төлөөлөгчдийн сонгогдсон тойрог, хорооны иргэдтэй хийх уулзалт, ярилцлага, зөвлөгөөнийг зохион байгуулах, Төлөөлөгчийн тойрогтоо ажиллах нөхцөлийг хангах;

11.1.8.Хурлын гадаад, дотоод харилцаатай холбогдолтой бичиг баримтыг боловсруулах, бэлтгэх, албан ажлын шугамаар гадаад оронд айлчлах, гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг зохион байгуулах;

11.1.9.Хурлын Төлөөлөгчид болон Ажлын албаны албан хаагчдад зориулсан сургалт, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг, бусад арга хэмжээг зохион байгуулах;

11.2.Хурлын Ажлын алба чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа хэлтэс, алба, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллана.

11.3.Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн дотоод журмыг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын тушаалаар батална.

Арван хоёр. Зохион байгуулалтын хэлтэс, түүний чиг үүрэг

12.1. Ажлын алба нь Зохион байгуулалтын хэлтэстэй байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.1.1.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг зарлах, бэлтгэлийг хангуулах, хурлаас гарах шийдвэрийн төслийг хянаж, хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах;

12.1.2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

12.1.3.Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Ажлын албаны даргаар батлуулах, биелэлтийг хангуулах;

12.1.4.Хурлын Ажлын алба болон төрийн албатай холбогдолтой хууль тогтоомж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

12.1.5.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Зөвлөлийн хуралдаанд шаардагдах мэдээ мэдээлэл, судалгаа, баримтыг холбогдох байгууллагуудаас гаргуулан авах;

12.1.6.Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжилт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

12.1.7.Хуралдаан, Зөвлөл, Хурлын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох тооцоо судалгаа, зар мэдээллийг Төлөөлөгчдөд хүргэх;

12.1.8.Хуралдааны байр танхим, шаардлагатай техник хэрэгслийг бэлтгэх, хуралдааны явцын тэмдэглэл, шийдвэрийг хэлбэржүүлэн гаргах, олон нийтэд мэдээлэх;

Арван гурав. Бусад зүйл

13.1. Энэхүү дүрмийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

13.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.